

БАТЛАВ.
ГЭР БУЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН ЯАМНЫ ТӨРИЙН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Салом тандуулж
Д.МӨНХЗУЛ

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ МЭДЭЭЛЛИЙН САН ҮҮСТЭХ АЖЛЫН ДААЛГАВАР БОЛОВСРУУЛАХ ҮЙЛЧИЛГЭЭ

1. Товч танилцуулга:

Хөгжлийн бэрхшээлтэй хүний талаарх мэдээллийн нэгдсэн санг бий болгох үндсэн зорилго нь хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй холбоотой өргөн хүрээний мэдээллийг бий болгох бөгөөд энэ нь тэдгээрийн амьдрах нөхцөл, бололцоо, оролцоо, тэгш байдлыг хангах, урьдчилан сэргийлэхэд чиглэсэн бодлого, төлөвлөлтийг хийх, хэрэгжилтийг хянах, үнэлэлт дүгнэлт өгөхөд оршино.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэдээллийн санг бий болгосноор тэдгээр иргэдийг үйлчилгээгээр хангах (нөхөн сэргээлт, бусад үйлчилгээ шаардлагатай хүмүүсийг таних), хүний амын үйл ажиллагааны түвшнийг тодорхойлох (нийгэмд оролцох оролцоо багассан хүмүүсийг таних), хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн халамжийн үйлчилгээний бүртгэл тэгш боломжоор хангах (үйл ажиллагаанд оролцоход хязгаарлалттай жирийн иргэдээс илүү их эрсдэлтэй хүмүүсийг таних)-д чиглэсэн үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, хянахад суурь мэдээлэл бий болох юм.

Түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй хүнийг бүртгэх мэдээллийн системийг мэдээллийг цуглуулах процессыг автоматжуулж шинжлэх ухааны үндэслэл бүхий нэгдмэл арга зүйгээр боловсруулах, чанар, уялдаа, бодит байдлыг нэмэгдүүлэх, нийтэд хүртээмжтэй, ил тод, шуурхай байдаар ашиглах боломж бүрдэх юм.

2. Ажлын хамрах хүрээ

Үйлчилгээний дэлгэрэнгүй:

- Системийн зорилго, хамрах хүрээ
- Системийн хэрэглэгч
- Бизнес процессын зураглал
- Системийн функциональ, функциональ бус шаардлага тодорхойлох
- Системийн оролт, гаралт
- Систем хөгжүүлэлтийн технологи тодорхойлох
- Систем хөгжүүлэлтийн нийт хугацаа тодорхойлох
- Бусад байгууллагатай мэдээлэл солилцооны хэрэгцээг тодорхойлох
- Албан тайлангийн загварууд

Гүйцэтгэх ажил, үр дүн: Систем захиалгаар хөгжүүлэх тендерийн ажлын даалгавар, хөгжүүлэлт ажлын даалгаврын дагуу хийгдсэн эсэхийг нягтлах

Хамтран ажиллах оролцогч талууд:

- Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комисс
- Нийгмийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захирагааны дэргэдэх эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комисс
- Нийгмийн хамгааллын байгууллага
- Хөдөлмөр зуучлалын байгууллага

	<ul style="list-style-type: none"> • Эрүүл мэндийн байгууллага • Хууль, шүүхийн байгууллага • Соёл урлагийн байгууллага • Онцгой байдлын байгууллага • Санхүү гааль, татварын байгууллага • Мэдээлэл, харилцаа холбооны байгууллага
3. Боловсруулах ажлын даалгаварт хамгийн багадаа тусгасан байх функциональ шаардлага	<p>Ажлын даалгаврын хамрах хүрээ нь бусад мэдээллийн сангидтай мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлэх замаар хөгжлийн бэрхшээлтэй хүний бүртгэлийн процессыг автоматжуулах. Гүйцэтгэгч нь дараах шаардлагуудыг илүү сайжруулсан процессын функциональ шаардлагыг санал болгож болно.</p> <p>Хөгжлийн бэрхшээлтэй хүний бүртгэлийн систем нь дараах хэсгүүдээс бүрдэнэ. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Бүртгэлт, хяналт удирдлага <ol style="list-style-type: none"> a. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн бүртгэл b. Хөгжлийн бэрхшээлтэй насан хүрсэн хүний бүртгэл 2. Үнэлгээний хэсэг 3. Сэргээн засах үйлчилгээний бүртгэл 4. Боловсролын үйлчилгээний бүртгэл 5. Нийгмийн хамгааллын үйлчилгээний бүртгэл <ol style="list-style-type: none"> a. Хөдөлмөр эрхлэлт b. Нийгмийн халамж c. Нийгмийн даатгал 6. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих хөтөлбөрүүдийн бүртгэл 7. Тайлангийн хэсэг <p>Функциональ шаардлага:</p> <ul style="list-style-type: none"> • Хөгжлийн бэрхшээлтэй хүний мэдээлэл болон тэдгээрийн шилжилт хөдөлгөөний бүртгэх, тус мэдээллийг насан туршид нь хадгалах боломжтой байна • Тухайн иргэний мэдээлэл давхардалгүй байна. Давхардсан тохиолдолд автоматаар мэдэгдэл, анхааруулга гаргадаг байна. • Системийн хэрэглэгч нь мэдээллийг аль ч талбараар эрэмбэлэх, хайх боломжтой байна. • Системд нэмэлтээр зөвшөөрөгдсөн файл мэдээллийг хавсаргах, дэлгэрэнгүй мэдээллийг оруулах боломжтой байна • Системд хавсаргах файлын хэмжээг хэрэглэгчийн эрхийн түвшнээс хамаарч тохируулдаг байх <p>Бусад мэдээлэл солилцооны системүүдтэй</p> <ol style="list-style-type: none"> 1. Танилт нэвтрэлтийн систем 2. Нийтийн түлхүүрийн дэд бүтэц 3. Мэдээлэл солилцооны бүртгэлийн систем 4. Мэдэгдэл хүргэх систем 5. Төрийн үйлчилгээний нэгдсэн систем <p>Төлбөр тооцооны систем</p>
4. Мэргэшил, турслага	Боловсрол : Дээд, бизнесийн удирдлага, программ хангамж, мэдээллийн технологийн чиглэлийн бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй.

	<p>Туршлага: Мэргэжлээрээ 10 ба түүнээс дээш жил тасралтгүй ажилласан. Ижил төрлийн буюу улс орны салбарын хэмжээнд өргөн хүрээтэй ашигладаг мэдээллийн системийг хөгжүүлэх төсөл гүйцэтгэж байсан туршлагатай.</p> <ul style="list-style-type: none"> Засгийн газар эсвэл төрийн бус байгууллагын төслүүд дээр ажилласан туршлагатай байх. <p>Хэлний ур чадвар: Англи хэлний зохион мэдлэгтэй (Техникийн англи хэлний өндөр мэдлэгтэй бол давуу тал болно)</p> <p>Мэргэжлийн чадвар:</p> <ol style="list-style-type: none"> Системийг удирдан зохион байгуулж, системийн шинжилгээ хийх чадвартай. Бизнесийн шаардлагыг ойлгох, шинжилгээ хийх ур чадвартай Систем хөгжүүлэлтийн амьдралын мөчлөг, төслийн удирдлага, Agile болон Waterfall зэрэг аргуудын талаар мэдлэгтэй Бизнесийн процессын шинжилгээ хийх чадвартай Системийн техникийн архитектур боловсруулах чадвартай. Мэдээллийн систем хөгжүүлэх, мэдээллийн сангийн зохион байгуулалтын талаар өндөр мэдлэгтэй. Тайлбар, шаардлагын баримт бичиг болон оролцогч талуудтай харилцахдаа маш сайн бичгийн харилцааны ур чадвартай байх. Хурал, илтгэл, оролцогч талуудын ярилцлага хийхэд хүчтэй ярианы харилцааны ур чадвартай Янз бүрийн түвшний оролцогч талуудтай харилцаа тогтоож, хадгалах чадвартай Ажлын талаарх шаардлагыг цуглуулж, баримтжуулах чадвартай Ашиглах тохиолдлууд, хэрэглэгчийн түүхүүд, функциональ тодорхойлолт болон бусад холбогдох баримт бичгийг бэлтгэх чадвартай Бизнес процесс болон ажлын урсгалуудыг зураглаж, загварчлах чадвартай Асуудлыг тодорхойлж, үндэс шалтгааныг шинжлэн, үр дүнтэй шийдлүүдийг санал болгох чадвартай
5. Үнэлгээний шалгуур	Гол шалгуур үзүүлэлт: Үйлчилгээ үзүүлэгчийн саналыг үнэлэх гол шалгуур үзүүлэлт нь мэргэжил, туршлага.
6. Төсөв, төлбөрийн нөхцөл	Төсөв: 19 сая. Төлбөрийн нөхцөл: Урьдчилгаа болон гүйцэтгэлээр.
7. Хугацаа	<ul style="list-style-type: none"> 1-2 сарын дотор ажлын даалгавар боловсруулах 6-8 сарын дотор хөгжүүлэлтийн чухал үе шатуудад яамтай хамтран хяналт тавих
8. Нөхцөл, болзол	Хууль, эрх зүйн шаардлага: Хөгжлийн бэрхшээлтэй хүний бүртгэлийн системийн бичиг баримт, системийн загварын зохигчийн эрхийг хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага эзэмшинэ.

Нууцлал: Ажлын шаардлагаар танилцсан албаны
болон хувь хүнтэй холбостой мэдээллийг нууцална.